

Мэргэжлийн ур чадварын олон улсын тэмцээнд амжилттай оролцсон хөгжлийн бэрхшээлтэй хүнд урамшуулал олгох журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Мэргэжлийн ур чадварын олон улсын тэмцээнд амжилттай оролцож амжилт гаргасан хөгжлийн бэрхшээлтэй иргэнд урамшуулал олгохтой холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д заасан этгээдэд тус хуулийн 18.1.5-д заасан урамшууллыг олгоход энэ журмыг баримтална. Энэхүү журам нь мэргэжлийн боловсролын сургалтаар эзэмшиж буй бүх мэргэжлийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс олон улсын тэмцээн, уралдаанд амжилттай оролцож байр эзэлсэн тохиолдолд үйлчилнэ.

Хоёр. Урамшуулал олгох болзол, урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэх

2.1. Дэлхийн болон бүс (тив)-ийн хэмжээнд зохиогддог мэргэжлийн ур чадварын тэмцээн, уралдаан(цаашид "тэмцээн, уралдаан" гэх)-д амжилттай оролцож, нэгдүгээр байр (алтан медаль), хоёрдугаар байр (мөнгөн медаль), гуравдугаар байр (хүрэл медаль), тусгай байрт шалгарсан оролцогчдыг урамшуулахад энэхүү журмыг баримтална

2.2. Тэмцээн, уралдаанд амжилттай оролцсон хөгжлийн бэрхшээлтэй хүн өөрийн харъяалагдах нутаг дэвсгэрийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст дараахь материалыг бүрдүүлнэ.

2.2.1. Иргэний үнэмлэх, гадаад паспортын хуулбар

2.2.2. Шагнуулах тухай өргөдөл

2.2.3. Сум, хороо, баг, дүүргийн засаг даргын тодорхойлолт

2.2.4. Харъяа байгууллагын тодорхойлолт

2.2.5. Хөгжлийн бэрхшээлийг тогтоосон комиссын шийдвэрийн хуулбар

2.2.6. Нийгмийн халамжийн тэтгэврийн дэвтрийн хуулбар

2.2.7. Тэмцээнд амжилттай оролцсоныг нотлох баримт, диплом, гэрчилгээний эх хувь, хуулбар

2.3. Монголын Абилимпийн холбоо нь олон улсын тэмцээн, уралдаанд оролцоходоо тэмцээн болохоос 30 хоногийн өмнө хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр багийн бүрэлдэхүүнийг батлуулсан байна. Бүрэлдэхүүнийг батлуулахад дараахь материалыг бүрдүүлнэ.

2.3.1. Тэмцээн, уралдааны талаарх дэлгэрэнгүй танилцуулга;

2.3.2. Тэмцээний албан ёсны урилга, заавар;

2.3.3. Абилимпийн холбооноос баталсан тэмцээнд оролцох оролцогчдын овог нэр, нас, хүйс, оролцох төрлийг тусгасан мэдүүлэг;

2.3.4. Хувийн туслах үйлчилгээ шаардлагатай хүнтэй хамт явах хувийн туслах болон дохионы хэлний орчуулагч, харааны бэрхшээлтэй иргэдийн хөтчийн хувийн мэдээлэл;

2.3.5. Багийн бүрэлдэхүүнд өөрийн орноос шүүгч оролцуулж болно.

2.4. Тэмцээн, уралдаан дууссанаас хойш 6 сарын дотор энэ журмын 2.2-д заасан материалыг бүрдүүлсэн байна.

2.4.1. Амжилттай оролцож, болзол хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүн 2.2-д заасан материалаа аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэст бүрдүүлж өгнө.

2.4.2. Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс нь тухайн хүний материалыг ажлын 10 хоногийн дотор хянаж Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт тохирох болзол, шагнал, урамшууллын тоо хэмжээний дүнг хүргүүлнэ.

2.4.3. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь энэхүү журмын 2.2-д заасан материалыг хянан үзээд шаардлага хангасан тохиолдолд шагнал, урамшуулал олгох тухай санал боловсруулан хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулна.

2.4.4. Шагнал, урамшууллын бүрдүүлэх материал хүлээн авснаас хойш ажлын 30 хоногийн дотор хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

2.5. Тэмцээн, уралдаанд амжилттай оролцсон оролцогчид шагнал, урамшууллыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр олгоно.

2.5.1. Тэмцээн, уралдаанд амжилттай оролцож алт, мөнгө, хүрэл медаль хүртсэн болон тусгай байр эзэлсэн оролцогчид шагнал, урамшуулал олгоно.

2.5.2. Тэмцээн, уралдаанд амжилттай оролцсон ч байр эзэлж чадаагүй, бусад орны тамирчдаас нөхөрсөгөөр бэлэглэсэн медальт байранд мөнгөн урамшуулал тооцохгүй болно.

2.5.3. Тэмцээний тайлан, оролцогчид олгох шагнал, урамшуулалтай холбоотой материалын бүрдэл дутуу хүнд мөнгөн урамшуулал олгохгүй болно.

2.5.4. Журмын 2.4-д заасан материалаа хүргүүлээгүй тохиолдолд хүчингүйд тооцож, мөнгөн урамшуулал олгохгүй.

Гурав. Урамшууллын хэмжээ, санхүүжилт

3.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүн олон улсын зэрэглэлийн тэмцээнд оролцож алт, мөнгө, хүрэл медаль хүртсэн болон тусгай байр эзэлсэн тохиолдолд 500.000-аас 3 сая төгрөгтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн мөнгөн урамшуулал олгоно.

3.1.1. Мэргэжлийн ур чадварын олон улсын тэмцээнд амжилттай оролцож алтан медаль хүртсэн тохиолдолд 3 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгоно.

3.1.2. Мэргэжлийн ур чадварын олон улсын тэмцээнд амжилттай оролцож мөнгөн медаль хүртсэн тохиолдолд 2 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгоно.

3.1.3. Мэргэжлийн ур чадварын олон улсын тэмцээнд амжилттай оролцож хүрэл медаль хүртсэн тохиолдолд 1 сая төгрөгийн мөнгөн урамшуулал олгоно.

3.1.4. Мэргэжлийн ур чадварын олон улсын тэмцээнд амжилттай оролцож тусгай байр эзэлсэн тохиолдолд 500.000 төгрөгийн мөнгөн урамшуулал олгоно.

3.2. Урамшууллыг мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр олгоно.

3.3. Мэргэжлийн ур чадварын олон улсын тэмцээнд амжилттай оролцож болзол хангасан оролцогчдын шаардлагатай зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн тухайн жилийн төсөвт тусгах замаар шийдвэрлэнэ.

Дөрөв. Бусад зүйл

4.1. Асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь амжилт үзүүлсэн оролцогчдын талаар мэдээллийн сан бүрдүүлж ажиллана.

4.2. Асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь амжилттай оролцсон оролцогчдыг олон нийтэд сурталчилан таниулна.

4.3. Амжилттай оролцсон оролцогчдыг тухайн амжилт үзүүлсэн чиглэлээр нь холбогдох аж ахуй нэгж, байгууллагатай холбож ажилд зуучлахад дэмжлэг үзүүлнэ.